



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/242/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Одонтуяа Утас: 325093 Цахим хаяг: odontuyal@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АУОС	Аудитын олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
НТГ	Нийслэлийн татварын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕГ	Татварын ерөнхий газар
АТӨЯХАТ	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
СБД	Сүхбаатар дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-08-25 № 129
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж, Нийслэлийн Татварын газраас шилжүүлсэн 32.1 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас 332.8 сая төгрөг нийт 364.9 сая төгрөгийн эх үүсвэрийг татварын орлого бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1420050035

C:\Users\manga\Desktop\Audit\2025\20250825\20250825 25 09 46 42.docx

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.26 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,408,728.15	119,593,514.62
33	АВЛАГА	0.00	28,072,590.00
335	Бусад авлага	0.00	28,072,590.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	28,072,590.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,408,728.15	91,520,924.62
354	Хангамжийн материал	72,408,728.15	91,520,924.62
35410	Бичиг хэргийн материал	8,106,761.53	3,562,098.00
35420	Аж ахуйн материал	62,461,966.62	87,958,826.62
35440	Түлш, шатах тослох материал	1,840,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	603,799,737.55	754,455,767.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	603,799,737.55	754,455,767.83
392	Биет хөрөнгө	573,141,977.55	723,798,007.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,060,130.00	170,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-45,060,130.00	-11,522,221.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	509,449,508.73	616,778,326.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-238,203,693.77	-350,377,602.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	333,194,245.57	379,322,245.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,618,682.98	-83,723,339.84
39217	Ном	3,320,600.00	3,320,600.00
393	Биет бус хөрөнгө	30,657,760.00	30,657,760.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,657,760.00	30,657,760.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	676,208,465.70	874,049,282.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	38,167,481.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	38,167,481.27
413	Өглөг	0.00	38,167,481.27
4136	Бусад өглөг	0.00	38,167,481.27
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	6,352,546.00
41363	ХХОАТ-ын өглөг	0.00	31,814,935.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	676,208,465.70	835,881,801.18
51	Засгийн газрын хувь оролцоо	676,208,465.70	835,881,801.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	550,440,563.78	550,440,563.78
51101	Өмч: - төрийн	550,440,563.78	550,440,563.78
512	Хуримтлагдсан үр дүн	125,482,333.80	285,155,669.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-121,985,078.67	125,482,333.80
51220	Тайлант үеийн үр дүн	247,467,412.47	159,673,335.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	285,568.12	285,568.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	676,208,465.70	874,049,282.45

2.2 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,675,515,916.06	4,546,389,549.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295,893,033.00	301,047,097.32
120	Нийтлэг татварын бус орлого	295,893,033.00	301,047,097.32
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	289,963,433.00	300,298,837.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	289,963,433.00	300,298,837.32
120009	Бусад орлого	5,929,600.00	748,260.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,379,622,883.06	4,245,342,452.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,946,122,883.06	3,822,523,652.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,946,122,883.06	3,822,523,652.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,500,000.00	422,818,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,500,000.00	422,818,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,428,048,503.59	4,386,716,213.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,428,048,503.59	4,386,716,213.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,300,992,315.10	3,950,392,916.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,759,072,367.96	2,921,961,105.20
210101	Үндсэн цалин	2,634,674,146.20	2,921,961,105.20
210102	Нэмэгдэл	33,195,306.19	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,305,852.01	0.00
210104	Урамшуулал	72,897,063.56	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	521,814,873.72	379,178,527.41
210201	Тэтгэврийн даатгал	501,236,373.72	379,178,527.41
210202	Тэтгэмжийн даатгал	3,993,200.00	0.00
210203	ҮОМШ өвчний даатгал	2,971,300.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,874,000.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,740,000.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	548,592,000.00	73,971,320.45
210301	Гэрэл цахилгаан	0.00	16,195,576.83
210302	Түлш, халаалт	0.00	8,750,000.97
210303	Цэвэр, бохир ус	0.00	3,309,742.65
210304	Байрны түрээс	548,592,000.00	45,716,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	161,888,253.62	165,473,111.21
210401	Бичиг хэрэг	94,966,196.73	74,930,133.53
210402	Тээвэр, шатахуун	14,950,000.00	14,639,800.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,376,372.89	12,659,077.68
210404	Ном, хэвлэл	3,248,500.00	7,172,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	1,675,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,347,184.00	54,396,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,697,000.00	95,202,110.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4,458,000.00	2,650,000.00
210604	Урсгал засвар	30,239,000.00	92,552,110.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,277,103.00	107,405,755.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,854,784.00	104,162,508.53
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,073.00	0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,934,000.00
210807	Газрын төлбөр	309,246.00	309,247.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,650,716.80	207,200,987.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,926,475.47	7,112,700.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	54,334,000.00	27,287,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	88,390,241.33	172,800,787.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,056,188.49	436,323,297.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,682,532.00	84,078,376.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,702,532.00	66,621,376.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,980,000.00	17,457,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,373,656.49	352,244,921.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,373,656.49	352,244,921.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	247,467,412.47	159,673,335.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	247,467,412.47	159,673,335.48

2.3 Аудит хийсэн 2025 оны мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,385,552,483.06	4,252,399,998.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,929,600.00	7,057,546.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,929,600.00	7,057,546.00
120009	Бусад орлого	5,929,600.00	7,057,546.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,379,622,883.06	4,245,342,452.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,946,122,883.06	3,822,523,652.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,946,122,883.06	3,822,523,652.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,500,000.00	422,818,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,500,000.00	422,818,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,354,510,483.06	4,229,241,998.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,354,510,483.06	4,229,241,998.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,226,654,294.57	3,764,846,111.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,933,837,465.24	2,894,921,931.93
210101	Үндсэн цалин	1,333,034,009.45	1,460,816,997.02
210102	Нэмэгдэл	490,312,694.96	585,383,010.52
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	198,048,265.98	214,164,426.51
210104	Урамшуулал	912,442,494.85	634,557,497.88

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	337,325,193.44	374,402,765.41
210201	Тэтгэврийн даатгал	225,158,712.18	258,277,180.70
210202	Тэтгэмжийн даатгал	27,313,800.00	31,590,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,534,500.00	15,700,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,534,480.96	15,412,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	55,783,700.30	53,421,284.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	548,592,000.00	73,971,320.45
210301	Гэрэл, цахилгаан	0.00	16,195,576.83
210302	Түлш, халаалт	0.00	8,750,000.97
210303	Цэвэр, бохир ус	0.00	3,309,742.65
210304	Байрны түрээс	548,592,000.00	45,716,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	162,599,794.89	181,752,967.68
210401	Бичиг хэрэг	74,300,500.00	45,804,700.00
210402	Тээвэр, шатахуун	15,700,000.00	12,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,029,810.89	20,708,877.68
210404	Ном, хэвлэл	23,971,500.00	30,799,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	1,675,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,597,984.00	70,363,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,197,000.00	95,521,610.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,958,000.00	2,969,500.00
210604	Урсгал засвар	30,239,000.00	92,552,110.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,623,319.00	112,896,115.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,201,000.00	109,652,868.53
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,073.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,934,000.00
210807	Газрын төлбөр	309,246.00	309,247.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,479,522.00	31,379,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,879,522.00	6,476,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,600,000.00	24,902,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,856,188.49	464,395,887.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,482,532.00	84,078,376.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,702,532.00	66,621,376.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,780,000.00	17,457,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,373,656.49	380,317,511.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,373,656.49	380,317,511.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,042,000.00	23,158,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,042,000.00	23,158,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,042,000.00	23,158,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,042,000.00	23,158,000.00
223001	Бусад хөрөнгө	31,042,000.00	23,158,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-31,042,000.00	-23,158,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	-121,985,078.67	428,741,053.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	-121,985,078.67	428,741,053.23
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	247,467,412.47	247,467,412.47
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	125,482,333.80	676,208,465.70
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	125,482,333.80	676,208,465.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	125,482,333.80	676,208,465.70
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	159,673,335.48	159,673,335.48
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	550,440,563.78	285,568.12	285,155,669.28	835,881,801.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,910,443,900.00	3,514,909,791.00	395,534,109.00	89.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,910,443,900.00	3,514,909,791.00	395,534,109.00	89.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,770,463,400.00	3,446,836,415.00	323,626,985.00	91.4%
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,148,677,600.00	2,894,921,931.93	253,755,668.07	91.9%
210101	Үндсэн цалин	1,487,673,600.00	1,460,816,997.02	26,856,602.98	98.2%
210102	Нэмэгдэл	652,322,900.00	585,383,010.52	66,939,889.48	89.7%
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	223,983,600.00	214,164,426.51	9,819,173.49	95.6%
210104	Урамшуулал	784,697,500.00	634,557,497.88	150,140,002.12	80.9%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	402,347,100.00	374,402,765.41	27,944,334.59	93.1%
210201	Тэтгэврийн даатгал	277,147,600.00	258,277,180.70	18,870,419.30	93.2%
210202	Тэтгэмжийн даатгал	31,590,700.00	31,590,700.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,700,900.00	15,700,900.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	15,412,900.00	15,412,700.00	200.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	62,495,000.00	53,421,284.71	9,073,715.29	85.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,305,900.00	73,971,320.45	33,334,579.55	68.9%
210301	Гэрэл, цахилгаан	44,548,200.00	16,195,576.83	28,352,623.17	36.4%
210302	Түлш, халаалт	10,777,500.00	8,750,000.97	2,027,499.03	81.2%
210303	Цэвэр, бохир ус	6,264,200.00	3,309,742.65	2,954,457.35	52.8%
210304	Байрны түрээс	45,716,000.00	45,716,000.00	0.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	53,146,900.00	50,480,730.68	2,666,169.32	95.0%
210401	Бичиг хэрэг	9,789,700.00	9,060,900.00	728,800.00	92.6%
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	400,000.00	300,000.00	57.1%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,683,000.00	9,682,040.68	959.32	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,675,900.00	1,675,900.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,298,300.00	29,661,890.00	1,636,410.00	94.8%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,434,000.00	12,433,610.00	390.00	100.0%
210604	Урсгал засвар	12,434,000.00	12,433,610.00	390.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,647,400.00	38,721,556.53	5,925,843.47	86.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,578,700.00	38,412,309.53	2,166,390.47	94.7%
210807	Газрын төлбөр	309,300.00	309,247.00	53.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,500.00	1,904,500.00	0.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,904,500.00	1,904,500.00	0.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,980,500.00	68,073,376.00	71,907,124.00	48.6%

2132	Бусад урсгал шилжүүлэг	139,980,500.00	68,073,376.00	71,907,124.00	48.6%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	136,944,500.00	66,621,376.00	70,323,124.00	48.6%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,036,000.00	1,452,000.00	1,584,000.00	47.8%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	93	79	14.00	84.9%
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	86	72	14.00	83.7%
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0.00	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	93	0	93.00	0.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	87	73	14.00	83.9%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,876,346.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,876,346.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,167,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	131,272,237.00
210401	Бичиг хэрэг	36,743,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,026,837.00
210404	Ном, хэвлэл	30,799,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,702,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,246,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,269,500.00
210602	Тавилга	17,858,000.00
210604	Урсгал засвар	80,118,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,174,559.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,240,559.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,934,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,474,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,476,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,998,000.00
213	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,703,650.00
213509	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,703,650.00
213509	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,703,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,005,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,005,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,005,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	429,876,346.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	429,876,346.00
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	422,818,800.00
120009	Бусад орлого	7,057,546.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 9,132.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайланд 2,779.7 мянган төгрөгийн зардал бууруулах гүйлгээ хийсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй 6,352.5 мянган төгрөгийн орлогыг өөрийн орлогоор тайлагнасан;

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НБББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д *“Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”*, санхүүгийн тайлагналын *“тохиолдсон байх”*, *“толилуулга”* гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 212,822.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 210,570.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 252.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Архивын ажилтантай байж архивын баримтын бүрдүүлэлт хийлгэхээр хувь хүнтэй гэрээ байгуулж, 2,000.0 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* 16 дугаар зүйлийн 16.5.2-т *“батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”*, 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан мөнгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. СБД-ийн ЗДТГ-аас нэмэлт санхүүжилтийн дансаар 172,382.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, орлого зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх зорилгоор нэр данс зөрүү гэх утгаар аж ахуйн нэгж рүү зарлагын гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 *“төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”*, 5.1.5-д *“хариуцлагатай байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.1-д *“төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т *“нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”* заалт, Төрийн аудит MNS6817-4:2020 *“материаллаг буруу илэрхийллийн шалтгаан болсон залилангийн эрсдэл үүсч*

болзошгүй зүйлсийг аудитор мэдэж байх ёстой ба үүнд худалдан авалт, буцалтгүй тусламж, өмч хувьчлал, эцсийн үр дүн болон мэдээллийг санаатайгаар худал мэдээлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах явдал хамаарна”, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: Залилангийн шинжтэй үйлдэл гаргаж, орлого зарлагыг нуун дарагдуулах гүйлгээ хийсэн албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй 29,788.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно" заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

3. Сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг зохицуулах төлбөр нэрээр ТББ-тай гэрээ байгуулж 8,400.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цалингийн дүнгээс илүү тайлагнаж, 252.0 мянган төгрөгийн шимтгэлийг төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө.", 21.9-д "Энэ хуулийн 7.3.1, 7.3.2-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, урамшууллаас даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, ажил олгогч нийгмийн даатгалын санд төлнө." заалт, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайланг, цалингийн дүнтэй тулган зөрүүгүй тайлагнаж хэвших.

2. Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Татварын Ерөнхий Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогчийг батлагдсан орон тоо, албан тушаалын тодорхойлолтын дагуу ажиллуулах.

3. Цалингийн баримтыг архивын нэгж болгож архивлаагүй байна. Энэ нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "архивын баримт" гэж архивт байнга болон түр хугацаагаар хадгалагдаж байгаа бүх төрлийн баримтыг;" 44 дүгээр зүйлийн 44.3-т "Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлсний дараа байгууллагын удирдлагаар батлуулж, оны эхнээс мөрдөж ажиллана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн баримтыг, харилцах дансны баримтаас салгаж холбогдох хууль, журмын дагуу архивлаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд зардал бууруулах гүйлгээ хийсэн	1	2,779.7	-	-	1	2,779.7	1	2,779.7	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй орлогыг орлогоор тайлагнасан	1	6,352.5	-	-	1	6,352.5	1	6,352.5	-	-	-	-
Дүн	2	9,132.2	-	-	2	9,132.2	2	9,132.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүүргийн ЗДТГ-аас нэмэлт санхүүжилтийн дансаар мөнгө авч, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн орлого, зарлагын гүйлгээг тайланд тусгахгүй байх зорилгоор нэр данс зөрүү дансны ангиллаар дамжуулан гүйлгээ хийсэн байна.	1	172,382.1							1	172,382.1		
Цалингийн баримтыг архивын нэгж болгож тусд нь архивлаагүй	1	-					1	-				
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цалингийн дүнгээс илүү тайлагнаж шимтгэлийг төлсөн.	1	252.0					1	252.0				

Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй, харьцуулалтын аргаар тендер зарлалгүйгээр бичиг хэргийн материалыг шууд худалдан авсан.	1	29,788.8			1	29,788.8				
Архивын ажилтантай байж архив цэгцлэх хувь хүнтэй гэрээ байгуулж архивын баримтын бүрдүүлэлт хийлгэж төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	2,000.0	1	2,000.0						
Сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг зохицуулах төлбөр нэрээр ТББ-тай гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	8,400.0			1	8,400.00				
Нягтлан бодогчийг улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.	1	-					1	0.0		
Дүн	7	212,822.9	1	2,000.0	1	38,188.8	3	252.0	1	172,382.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд нийт 23 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээг зарлагын мөнгөн гүйлгээний 36,722.0 мянган төгрөгийн 11 мэдээллийг мэдээлээгүй.	1	36,722.0					1	36,722.0
Үндсэн үйл ажиллагааных нь зардлыг улсын төсвөөс баталж өгсөн байхад үндсэн чиг үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө орон нутгийн төсвөөс давхардуулан санхүүжилт авч зарцуулсан байна.	1	357,172.7			-	-	1	357,172.7
Дүн	2	393,894.7	-	-	-	-	2	393,894.7